

ЗӨВШӨӨРСӨН
ЧАНДМАНЬ НАЛАЙХ ОНӨААТҮГ
ЗАХИРАЛ Г.ЧУЛУУНБАТ
2018 оны дугаар сар

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2018 оны 06 сарын 30 өдөр

1. Барилга объектын нэр, хаяг : **Нутгийн захиргааны ордон**
2. Барилга объектын байршил: **7-р хороо Өвөршанд, Монсульт ШТС-ын хойно 56484.7 м2 барилгажих газартай.**

3. Цэвэр усны тооцоо:

а/ Ахуйн ундны хэрэгцээ	10	=	м3/хоног
б/ Технологийн		=	м3/хоног
в/ Галын зориулалт	1	=	м3/хоног
г/ Усалгаа	1	=	м3/хоног
Бүгд	12	=	м3/хоног

4. Цэвэр усны холболт хийх байршилт, өндөржилт, шугамын даралт, диаметр, материал

Шинээр баригдах УДДТөв-өөс салбарласан 2-р хэлхээ буюу Налайх дүүргийн спорт цогцолбор руу явсан хүйтэн усны шугамнаас шинээр худаг гаргаж ф76мм шугамаар таслах хаалттай угсрах.

5. Усан хангамжийн эх үүсвэр

6. Бохир ус	а/ Ахуйн хэрэгцээнээс гарах	10	=	м3/хоног
	б/ Технологийн хэрэгцээнээс гарах		=	м3/хоног
	Бүгд	10	=	м3/хоног

7. Бохир усны шугамын холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр, материал:

Шинэ Налайх хорооллын БУ-35 дугаар худагруу бохирын шугамны уклоньг тааруулж ф150 мм шугамаар хяналтын 10 худаг гаргаж холболт хийх.

8. Үйлдвэрлэлийн газруудаас гарах бохир усны найрлага

а/ Умбуур мг/л.....	15-20.....
б/ БХХШ мг/л.....	20.....
в/ ХХШ мг/л.....	50.....

г/ Нефть нефтэн бүтээгдэхүүний мг/л

д/ Нефть угаагч бодис мг/л

е/ Бусад хорт бодисууд мг/л

9. Захиалагч ба зураг төслийн байгууллагууд нь техникийн норм, дүрэм, хатуу баримтлах ба зураг төслийг ус сувгийн байгууллагатай зөвшилцөх шаардлагатай

10. Ус хангамж, ариутгах татуургын системийг угаалт, шахалт, туршилт, тохируулгын ажлын зардлыг зураг төсөвт тусгах.

11. Энэхүү техникийн нөхцөл олгосон өдрөөс хойш 2 жилийн дотор хүчинтэй.

Техникийн нөхцөлийн хугацаа дууссан үед захиалагч байгууллага, ус сувгийн байгууллагад сунгуулах буюу дахин шинээр техникийн нөхцөл авах асуудлыг тавина.

12. Барилга угсралтын ажлын явцад зураг төсөлд өөрчлөлт орох шаардлага гарвал ус сувгийн байгууллагаар хянуулж, зураг зохиогчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

13. Техникийн нөхцөлийн нэг хувийг холбогдох баримт бичгүүдийн хамт дүүргийн ЗДТГ өгнө.

14. Ус сувгийн байгууламжийг барихад газар доорхи шугам сүлжээг зөөх, дайрч гарах, зам бут, сөөг эвдэх тохиолдолд тэдгээрийг заавал сэргээхэд гарах зардлыг төсөвт тусгах

15. Усны хэмжүүрийн зангилгааг үзлэг хийхэд тохиромжтой ус тусгаарлагчтай, гэрэлтүүлэгчтэй +5С-ээс дээш температуртай өрөөнд байрлуулна.

16. Бусад шаардлагууд, урьдчилан цэвэрлэх байгууламж, хийх засварлах, эсвэл одоо байгаа шугам сүлжээг өргөтгөх ба шинээр тавих.

Урьдчилан цэвэрлэх байгууламж хэрэггүй

17. Дараагийн өргөтгөл эхлэх хугацаа, өргөтгөлийн чадал:

18. Уул объектыг барих талаар дээд байгууллагын тогтоол шийдвэрийн заалт:

Дүүргийн Засаг даргын А/657 тоот шийдвэртэй.

19. Техникийн нөхцөлийг явуулсан газрууд:

20. Техникийн нөхцөлийг хангасан байдал:

21. Цэвэр усны төв шугамаас аж ахуйн нэгж, албан байгууллагад ус өгөх зөвшөөрөл өгөхийг хориглоно.

22. Техникийн нөхцөл гарснаас хойш 1 жилийн дотор холболт хийгээгүй тохиолдолд техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно.

23 Цэвэр усны шугамаас дараагийн байгууллагад цэвэр ус өгөхийг хориглоно..

24. Нэмж тусгах нөхцөлүүд:

1. Манай байгууллагатай хийсэн гэрээний хугацаа дууссан тохиолдолд гэрээг дахин хийх.

2. Цэвэр усны шугаман халуун хүйтэн усны тоолуур тавих.

3. Цэвэр усны шугамыг хөлдөлтөөс хамгаалж дулаалга хийх

4. Бохирын шугамыг хөлдөлтөөс хамгаалж дулаалга хийх

5. Бохирын шугам хөлдсөн тохиолдолд хэвийн болгох ажиллагааг хэргэлэгч хариуцана.

ХЯНАСАН: ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН: ЦУХ ХЭСГИЙН ИНЖЕНЕР

3. БОЛДБААТАР

А.УУГАНЧИМЭГ



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 1984/2018.

2018 оны 06 сарын 20 өдөр

Улаанбаатар хс

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1	Хүсэлтийн дугаар:	18150045
1.2	Хэрэглэгчийн нэр, регистр:	НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ
1.3	Хэрэглэгчийн байршил:	Налайх дүүрэг, 7-р хороо
1.4	Ажил үйлчилгээний зориулалт:	Үйлчилгээ /Нутгийн захиргааны ордон/
1.5	Техникийн нөхцөл олгох үндэслэл:	1) Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 000439161 тоот гэрчилгээ. 2) Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 3/41 тоот албан бичиг. 3) УБЦТС ТӨХК-ийн НТТ-ийн 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 33/61, 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 16/2018 тоот бичиг.
1.6	Техникийн нөхцөлийн ангилал:	Шинэ холболт
1.7	Тооцооны бүрэн чадал:	630 кВА (тоогоор) /Зургаан зуун гуч/ (үсгээр)

Хоёр. Холболтын цэг:

2.1	110/35/10 кВ-ын Налайх дэд станцын 10 кВ талаас тэжээгдэх Хөл Налайх цэцэрлэгт хүрээлэн ХТГ-ийн 10 кВ-ын I ба II секцнээс кабель шугам татаж шинээр баригдах дэд өртөөг тэжээх.
2.2	Шинээр баригдах дэд өртөөний 0.4 кВ-ын ын I ба II секцнээс кабель шугам татаж барилгыг тэжээх.
2.3	Тус техникийн нөхцөлийн тусгай заалтад тусгагдсан шугамыг батлагдсан зураг төслийн дагуу зөөх

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Дэд өртөөний болон орон сууцны барилга, үйлчилгээний барилгын 0,4 кВ талын ерөнхий оруулгад DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон тоолуур, 5А-ийн тоолуур, гүйдлийн трансформаторыг тусгай хайрцагт суурилуулах.
-----	--

11600 + 275000 = 446000

Дөрөв. Тусгай шаардлага:

- | | |
|-----|--|
| 4.1 | Олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 2*630 кВА чадалтай 10/0.4 кВ-ын хүчдэлийн тохируулгын 5 шатлалтай трансформатортай 1 ком ХТП шинээр барих. |
| 4.2 | 110/35/10 кВ-ын Налайх дэд станцаас тэжээгддэг 10 кВ-ын Тэлмэн АБ цахилгаан дамжуулах агаарын шугам барилгын талбайд орсон тул эзэмшигчээс нь зөвшөөрөл авч тус шугамын зөөх. |
| 4.3 | Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах. |
| 4.4 | Шугам тоноглол нь хоёр талын цахилгааны эх үүсвэрээс тэжээлтэй болон автомат сэлгэн залгагч төхөөрөмж суурилуулсан мөн аваарийн нөөц тэжээлийн эх үүсвэр /дизель, генератор/-тэй бол харьяа түгээх төвтэй Шуурхай ажиллагааны гэрээ байгуулах. |
| 4.5 | Богино залгааны гэмтэл заагч датчикийг фаз тус бүр дээр суурилуулах. Датчикийн техникийн тодорхойлолтыг Техникийн бодлого, зохицуулалтын хэлтсээс авах. |
| 4.6 | Дэд станцад суурилуулж буй тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, $\pm 10\%$ -ийн хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажилладаг байх. |

Тав. Дор дурдсан техникийн даалгавар хууль дүрмийг мөрдөх:




- | | |
|-----|---|
| 5.1 | Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, дүрэм цонхноос үзэх |
| 5.2 | Дэд өртөө болон шугамын "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах. |
| 5.3 | Щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх. |
| 5.4 | "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнга үзлэг шалгалт хийж хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх. |
| 5.5 | "Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9 хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй. |
| 5.6 | "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.10-ийн дагуу түгээх, зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах |
| 5.7 | "Эрчим хүчний тухай" 30.1.12. эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө хариуцах. Хэрэглэгч уг эвдрэл, гэмтлийг засах шаардлагатай арга хэмжээ авахгүй бол хангагч засварыг хийж, гарсан зардлаа хэрэглэгчээс шаардан авах эрхтэй |
| 5.8 | "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.13.нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барьж байгаа учир шинээр барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх. |
| 5.9 | Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх. |

5.10 Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад

6.1 Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж, гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.

Комиссын гишүүд:

 Л.Ганзориг
 Т.Батцэцэг
 Т.Мөнхболд
Г.Баттөмөр
17. ДА Н.Батцэнгэл - 2

1. 1. 1.

2. 2. 2.

3. 3. 3.

4. 4. 4.

5. 5. 5.

6. 6. 6.

7. 7. 7.

8. 8. 8.

9. 9. 9.

10. 10. 10.

11. 11. 11.

12. 12. 12.

13. 13. 13.


14. 14. 14.

15. 15. 15.

16. 16. 16.

17. 17. 17.

18. 18. 18.

БАТЛАВ.
"НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ИЙН
ДЭД ЗАХИРАЛ  Ц.ЭНХТҮВШИН

Техникийн нөхцөл № 18007


Огноо: 2018.06.19

1. Хэрэглэгчийн нэр: "Зураг төсөл консалтинг" ХХК,
Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар (Налайх дүүргийн нутгийн захиргааны ордны барилга)
2. Хэрэглэгчийн байршил: 7-р хороо, Өвөршанд, Монсульт ШТС-ын хойно
3. Хэрэглэгчийн эзэлхүүн:
4. Дулааны хэрэглээ:

• Халаалт	0.75	Гкал/ц
• Хэрэгцээний халуун ус	0.15	Гкал/ц
• Агааржуулалт	0.23	Гкал/ц
• Нийлбэр ачаалал	1.13	Гкал/ц
5. Холболт авах тухайн цэг дээрх пьезометрийн напор /түрэлт/
6. Халаалт авах худгийн дугаар, шугамын диаметр
- Шинээр баригдах УДДТ-өөс салбарласан 2-р хэлхээ буюу Налайх дүүргийн спорт цогцолбор руу явсан дулааны шугамын дунд шинэ худаг гарган Ф100-н таслах хаалтуудыг угсарна.
- Гаргалгааны хаалт угсарсан шинэ худгаас барилгын узель хүртэл м газарт Ф100мм-ийн голчтой хос шугамыг стандартын сувагт гулсах тулгууртайгаар угсарна.
- Дотор халаалтын системд балансын хаалт, термостат вентиль суурилуулах.
- Төвлөрсөн дулаан хангамжийн системийн техник ашиглалтын шаардлага хангасан узелийг дагалдах тоног төхөөрөмжүүдийн хамт, стандартын дагуу суурилуулах.
7. Хэрэглэгчийн шугаман дээр тавигдах шайбны диаметр
8. Гадна дулаан хангамжийн систем, узель ба дотор системийн угаалт, шахалтыг хийн акт үйлдэн хүлээлгэж өгөх.
9. "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30 дугаар зүйлийн 30.1.10-д заасны дагуу түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах.
10. Шугамын трасс сонголт, холболтыг хийхдээ салаа шугам эзэмшигч байгууллага, шугамын трасс дагуух газар эзэмшигч аж ахуй нэгж байгууллага, иргэдтэй урьдчилан зөвшөөрөлцөх.
11. Дулааны шугам, тоноглол, хянах хэмжих хэрэгсэл, дулаалга зэргийг сонгох, угсрахдаа холбогдох БНБД, ТАД, ААД-ийг чанд мөрдөж ажиллах.
12. Техникийн нөхцөл олгосноос хойш нэг жилийн хугацаанд гаргалгааны хаалтууд тавигдаагүй, холболт хийгдээгүй, дулаан аваагүй нөхцөлд техникийн нөхцлийг хүчингүй болсонд тооцно.

Техникийн нөхцөл олгосон:

ДШС-ний инженер



П.Бат-Амгалан

Хураамжийн тооцоог хянасан:

Борлуулалтын менежер



М.Ариунзаяа



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар: **ҮСГ-18/2**

**Захиалагч
байгууллага:**

Хэрэглэгчийн нэр: Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын Газар ОНӨААТҮГ

Харилцах утас: 31-16-30 , 32-32-49

1. Байршил: Налайх 7-р хороо

2. Зориулалт: ЗДТ-ын барилга

**3. Холбооны
хэрэгцээ:** /урьдчилсан тооцоогоор/
Телефон тоо (ширхэгээр)

4. Техникийн онцгой нөхцөл: Харилцаа Холбооны Зохицуулах хорооноос олгогдсон үндсэн сүлжээ байгуулах бүрэн эрхийнхээ дагуу холбоожуулах техникийн нөхцлийг зөвхөн МХС ХХК олгох бөгөөд техникийн нөхцөлгүйгээр холбооны бүх төрлийн үйлчилгээний зориулалттайгаар кабель татах болон шилжүүлсэн тохиолдолд уг барилга объектыг техникийн болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

5. Техникийн үндсэн нөхцөл

- 5.1. МХС ХХК-ний байрнаас ХШ-6 ын хүрээний РС 1-16 худгаар дайруулан ХШ-10 ын хүрээний РС 1-22 худаг хүртэл бэлэн байгаа сувагчлалаар явуулж түүнээс цааш барилга хүртэл 110 мм-н 2 яндантай сувагчлал хийх ба шинээр хийх сувагчлалыг 1,0-1,2 метрийн гүнд суурилуулна.
- 5.2. Сувагчлал хооронд худаг суурилуулах зай хэмжээг 90 метрээс хэтрэхгүй байхаар тооцох ба ТБУХ -1 загварын худаг суурилуулна.
- 5.3. Физик кабелийг станцын 4-7-7 –р грд цэнэглэж одоо байгаа сувагчлал болон шинээр хийсэн сувагчлалаар татан барилгад оруулж төгсгөлийн төхөөрөмжид холбоно.
- 5.4. Уг техникийн нөхцөлд зориулж гр 4-7 -н 7 -р хэсгийг эхний ээлжинд нөөцлөв.
- 5.5. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагатай.

6. Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцлүүд:

- 6.1. Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 6597:2016, MNS 5017:2001, MNS 6305:2012, MNS 6668:2017 уудын шаардлагуудыг баримтлан гүйцэтгэх.
- 6.2. Шинээр хийх сувагчлалын трассын урт 5 метрээс илүү зайд хийх тохиолдолд ажлын зургийг Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын холбоо хариуцсан мэргэжилтэн болон инженерийн шугам сүлжээний газруудын холбогдох албан тушаалтнуудаар шалгуулан баталгаажуулсан байх шаардлагатай.
- 6.3. Хэрэглэгчийн шугамын угсралтын ажил барилгын зураг төсөвт байхгүй болон хийгдээгүй бол захиалагчид мэдэгдэж төсөв зурагт оруулах.
- 6.4. Кабелийн хуваарилах хайрцагны байрлалыг хэрэглэгчийн шугамын нягтралын цэгт болон техник ашиглалтын шаардлага хангахуйц байдлаар сонгон суурилуулахаар технологийн норм хэмжээг зааж оруулах.

7. Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:

- 7.1. Угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төсөв техникийн нөхцлийн дагуу хийгдсэн эсэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ий ҮСГ-ын Налайх төвийн холбогдох нэгжээр (Утас:7023-2007) хянуулан баталгааг авсан байх.
- 7.2. Газар шорооны ажил гүйцэтгэхдээ харъяалагдах нэгжийн ахлах инженер болон инженерээр шалгуулан далд ажлын акт үйлдэж хүлээн авах ажлын актанд хавсаргах.
- 7.3. Кабель шугамын угсралт болон газар шорооны ажлыг эхлэхдээ харяалагдах салбарын ерөнхий инженерээс албан ёсны зөвшөөрлийг авч тухайн харъяалагдах нэгжийн ахлах инженерийн хяналтан дор гүйцэтгэнэ.
- 7.4. Шинээр татсан кабель болон кробканд тэмдэглэгээг бүрэн хийсэн байх.
- 7.5. Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулсан байх.
- 7.6. Хэрэглэгч холбох нөхцлийг бүрдүүлэхийн тулд барилгын дотор монтажийн угсралтыг Монгол улсын стандарт MNS 5471:2005 ерөнхий шаардлагын дагуу хийгдсэн, техникийн акты хамт гадна холбооны угсралтын ажлыг хүлээж авна. Шинээр хийсэн сувагчлалын трассыг Нийслэлийн мэдээллийн санд оруулсан тодорхойлолт бичиг болон CD-ны хамт техникийн актыг Налайх төвд хүлээлгэн өгнө.

8. Захиалагчид ашиглалтын үед тавигдах шаардлага:

Шинээр хийгдсэн холбооны худаг сувагчлал болон кабель шугам нь хотын телефоны кабель шугамын сүлжээнд холбогдох тул:

- 8.1. Танай эдэлбэр газарт суурилуулагдсан холбооны сувагчлал болон кабелийн гадны механик гэмтэлээс хамгаална.
 - 8.2. Уг сувагчлалын трассыг цааш нь үргэлжлүүлэх болон шинээр кабель татах боломжийг хангах.
 - 8.3. Худаг сувагчлалд техникийн ашиглалтыг хоногийн ямар ч үед ажил үйлчилгээг шуурхай гүйцэтгэх боломжоор бүрэн хангах.
- 9. Техникийн нөхцлийг НХОГ ын ОНӨААТҮГ -н даргын 2017 оны 12 -р сарын 14 -ний өдрийн 3/3143 тоот албан бичгийг үндэслэн олгов.**


10. Угсралтын ажил дууссаны дараа хэмжилт шалгалт хийлгэж Налайх төвд техникийн актаар хүлээлгэн өгсний дараа сүлжээнд холбох зөвшөөрлийг авна.

11. ЭНЭХҮҮ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ НЬ ОЛГОСОН ӨДРӨЭС ХОЙШ 1 ЖИЛИЙН ХУГАЦААНД ХҮЧИНТЭЙ.

Танилцсан:

Хянасан:

Боловсруулсан:



А.Гантулга /ТАГ-ын захирал/

Б.Алтаншагай /ҮСГ-ын захирал/

Т.Одончимэг /ҮСГ-ын ерөнхий инженер /

